

1. Ахлах удирдагч

Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг:

- Хөтөлбөр үйл ажиллагааны хүрээнд зуслангийн стандарт, холбогдох журам, дүрмийн дагуу ёс зүйн өндөр хэм хэмжээнд зуслангийн бүлгийн багш нарыг удирдан урлаг, спортын тэмцээн, сургалтуудыг зуслангийн мэргэжилтний удирдлагад зохион байгуулна.
- Багш нарын үйл ажиллагааг хянах, идэвх ур чадварыг дүгнэх, зөвлөгөө өгнө.
- Зуслангийн 7 хоногийн хөтөлбөрийн дагуу бэлтгэл ажлыг хангах, даалгавар өгч эргэх холбоотой ажиллана.
- Хөтөлбөрт заагдсан үйл ажиллагаануудыг уран сайхны хөтлөлт хийн зохион байгуулах, удирдан явуулна.

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Дээд боловсролтой, хүүхдийн зусланд 3-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх
- Зусланд ажиллах ажилтны мэргэжил, мэргэшлийн сургалтад суусан байх
- Хүүхдийн эрхэд суурилсан дүрэм журам, бодлого, стандартын зохих мэдлэгтэй байх
- Компьютерын хэрэглээний программуудыг зохих түвшинд эзэмшсэн байх
- Албан хэрэг хөтлөлт, бичиг баримтын стандартын зохих мэдлэгтэй байх
- Харилцааны ур чадвар эзэмшсэн байх
- Нас: 25-аас дээш

Мэдвэл зохих дүрэм, журам, стандарт:

- Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага, Монгол Улсын Стандарт MNS 5633:2013
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Хүүхдийн эрхийн конвенц
- Хүүхэд хамгааллын бодлого